An illustration in shades of green showing a group of people sitting on the floor. On the left, two women are huddled together, one with her arm around the other. In the center, a man sits cross-legged, looking towards the viewer. To his right, another man wearing a cap is leaning over a large document or map on the floor. On the far right, a young boy is also looking at the document. The background consists of simple lines suggesting an indoor setting.

Нээлттэй байдлаар,
хэрэгжүүлэхээс өмнө,
мэдээлэлжсэн баймааж нь
зөвшөөрөл олгох эрхийн
тухай гарын авлага

2013 оны 1 дүгээр сард хэвлэв.

Оксфам Австрали
132 Лайсестэр стрийт
Карлтон 3053
Виктория
Австрали
ABN 18055208636
Утас: +61 3 9289 9444
Вэбсайт: www.oxfam.org.au

Зохиогчид: Кристина Хилл, Серена Лиллвайт ба Михайл Симон

Хянан тохиолдуулсан: Талия Эйлон ба Мауреен Батгэйт

Зураач: Доминик Фелла

Дизайнер: Пааоли Смитт

Хэвлэсэн: Жоселин Тан

Хэвлэлийн газар: Комплийт Колор Принтинг

Хувь оруулсан: Челсиа Хаггет ба Клэйр Хуссин

Хэрэглэгчдийн ашигласан цаасыг 100% дахин боловсруулсан, цайруулаагүй Циклс ПринтМатт цаасаар ургамлын бэх ашиглан хэвлэсэн болно.

Талархлын үг

Энэхүү бүтээлийг боловсруулахад зөвлөн тусалсан олон байгууллага, хүмүүст Оксфам байгууллага гүн талархал илэрхийлж байна. Ялангуяа Хүмүүсийн Ойн хөтөлбөр, Олон улсын гол, Дэлхийн нөөцийн институт, Оксфам Америк, Гадаадын хөгжлийн Католик байгууллага, Азийн уугуул иргэдийн пакт зэрэг байгууллагууд ихээхэн хувь нэмэр оруулж, зөвлөн тусалсанд талархаж байна. Мөн Ертөнцийн тэрэгчин сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлсэнд талархаж байна.

ӨМНӨХ ҮГ

Олон нийт, ард иргэд, хувь хүмүүсийн зүгээс эдлэх ёстой эрхээ хэрэгжүүлэх, хүсэл сонирхлоо илэрхийлэх явцдаа нилээд бэрхшээлтэй тулгарч, аюулгүй байдалд нь аюул учирч байгааг Оксфам байгууллагынхан бид олж харсан юм.

Иргэдэд учирч болзошгүй аюулгүй байдлын аливаа эрсдэлд анхааралтай хандаж хэрхэн хариу өгөх талаар зөвлөмж болгох зорилгоор энэхүү гарын авлагыг толилуулж байна.

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийн тухай гарын авлагын зорилго

Энэхүү гарын авлага нь Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрх гэж юу болох тухай танилцуулах юм. Үүгээр хүн бүрийн эдлэх ёстой Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийн тухай мэдээлж, хүмүүсийн амьдралд хожим хойно хэзээ нэг цагт нөлөөлж болохуйц хөгжлийн том хэмжээний төсөл болох далан барих, ойд мод хийх, уурхай болоод бусад дэд бүтцийн хөгжлийн томоохон төслүүдийн талаар санал бодлоо илэрхийлэхэд энэхүү эрх Танд хэрхэн тустай байх тухай өгүүлнэ.

Бид газар нутаг дээрээ юу хийхээ өөрсдөө шийдэх эрхтэй. Хүний эрхийн олон улсын хуулиар энэхүү зарчмыг баталгаажуулан “хүн бүр бие даасан байх эрхтэй” хэмээн заасан бөгөөд “хүн бүр эдийн засгийн, нийгмийн, соёлын, хөгжлийн эрхээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх ёстой” гэж баталгаажуулсан нь бие даасан байдлын тухай эрхтэй шууд холбоотой юм.

Томоохон хэмжээний хөгжлийн төслүүдийн нөлөөлөлд өртөн нэрвэгдэж буй олон нийт, оршин суугчдад туслалцаа үзүүлж буй байгууллагуудад энэхүү гарын авлагыг тусламж болгон толилуулж байна. Энэ нь олон нийт ба төсөл хэрэгжүүлэгчид болох засгийн газар, компани, санхүүжүүлэгчийн хооронд яриа хэлэлцээр өрнүүлэхэд туслах практик хэрэглүүр мөн.

Тухайн төслийн нөлөөлөлд автаж буй уугуул оршин суугчдын зүгээс Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхээ эдлэхийн тулд тэдэнд туслах зорилгоор долоон үе шаттай алхам бүхий аргачлалыг энд багтаасан юм. Төслийн нөлөөлөлд өртөн нэрвэгдэж буй оршин суугчдад зориулсан зарчмуудыг мөн адил толилуулна. Гарын авлагын нэг бүлэг нь оршин суугчид өөрсдийн эдлэх ёстой эрхээ ойлгож авах, ашиглах тухай хэрэгтэй мэдээллийг агуулсан байгаа. Буруу зөрүү байдалд хүргэж болзошгүй тохиолдолд ашиглах “анхааруулга”, оршин суугчдад учирч болзошгүй зарим бэрхшээлээс энд өгүүлнэ.

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийг танилцуулах нь

Төсөл хэрэгжүүлэхийг зөвшөөрөх үү, эс зөвшөөрөх үү гэдэг дээр уугуул оршин суугчид эрхтэй гэдгээ хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дотоодын түвшинд засгийн газартайгаа, олон улсын түвшинд ч, мөн компаниудтай нилээд тэмцэл явуулж ирсэн билээ. Уугуул оршин суугчдын хувьд өөрсдийнхөө ирээдүй болоод тэдний хойч үеийн ирээдүйгээ хамгаалахын төлөө тэмцэж буй эрх юм. “Тэдний амьдарч буй газар нутаг, хил хязгаар, байгалийн баялгийг нь хөндсөн аливаа үйл ажиллагаа явуулахдаа чөлөөт, урьдчилсан ба мэдээлэлжсэн байдлаар тэднээс зөвшөөрөл авах ёстой” эрхийг энд хэлж байгаа юм.

Үүнийг товчоор Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрх буюу НХМЗ хэмээн нэрлэж байна.

Уул уурхай, далан барих, хурдны зам тавих, тариалангийн талбай бий болгох, мод бэлтгэл зэрэг томоохон хэмжээний хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх нөхцөлд энэхүү эрх зөрчигддөг. Зарим тохиолдолд уугуул иргэд ба оршин суугчид, олон нийт иймэрхүү үйл ажиллагааны төлөвлөлт ба шийдвэр гаргахад оролцдоггүй хаягддаг талтай. Үр дүн нь хүмүүсийн сэтгэлийг донсолгодог

байна. Уугуул иргэд ба оршин суугчид нь өөрсдийн ахуй амьдрал ба соёлоосоо хаягдах эрсдэлд ордог. Газрыг нь тэдний зөвшөөрөлгүйгээр булаан авч шамшигдуулдаг. Зарим тохиолдолд оршин суугчдад хангалтгүй хэмжээний төлбөр төлөөд өөр газарт хүчээр нүүлгэн шилжүүлдэг байна.

Ийм явдлыг гаргахгүй байх ёстой. Уугуул иргэдийн хувьд олон улсын хуулиуд ба НҮБ-ийн Уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглалаар (НҮБУИЭТ) эрх нь хамгаалагддаг. Төслийн нөлөөлөлд өртсөн бусад хүмүүсийн хувьд ч хамгаалалтын арга хэрэгсэл үйлчилдэг. Уугуул иргэд нь амьдарч буй газар нутаг, хил хязгаар, байгалийн баялгийг нь хөндсөн аливаа шийдвэр гаргахад оролцох эрхтэй. Тэд энэхүү эрхийнхээ дагуу нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох, эсвэл олгохгүй байж чадах эрхтэй гэсэн үг. Тэд өөрсдийн хүссэн, төлөвлөсөн ёсоор хамтын шийдвэрт хүрэх эрхтэй.

Төслийн нөлөөлөлд нэрвэгдсэн уугуул иргэдийг төслийг зөвшилцөх, төлөвлөх бүх шатанд бүрэн дүүрэн, үр өгөөжтэйгөөр оролцуулахыг дэмжих ёстой.

Бэрхшээл сорилтууд

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхээ эдэлнэ гэдэг бас амаргүй зүйл. Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох үйл явц нь байнга үргэлжлэх, заримдаа хэдэн жилээр ч сунжирдаг талтай. Төслийн нөлөөлөлд нэрвэгдсэн иргэд, оршин суугчид нь зөвшилцөл явуулахыг шаардах, түүнчлэн уугуул иргэдийн хувьд Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийг нь хүндэтгэж хандах шаардлага тавих эрхтэй. Энэхүү эрхийг тэрийн болгон шууд дэмжин хэрэгжүүлж чаддаггүй. Зарим засгийн газар, компани, санхүүжүүлэгчийн хувьд энэхүү эрхийг хүндэтгэн үзэхэд нилээд ахиц гаргаж, төсөл хэрэгжүүлэхдээ баримтлах бодлого, амлалтандаа тусгаж боловсруулсан байдаг. Харин ихэнх тохиолдолд Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийг хүндэтгэн үзэхгүй, хэрэгжүүлэхгүй, сайтар ойлгохгүй байдалтай байгаа.

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийг хэрэгжүүлэхийг шаардсан үндэсний түвшний хууль журмууд үйлчилж болно. Иймээс төслийн үр дагаварт нэрвэгдсэн хүмүүс дотоодын хууль тогтоомжоо сайтар судалж мэдсэн байвал зохино.

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийг хэн эдлэх ёстой вэ?

НХМЗ нь НҮБ-ийн Уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглалаар (НҮБУИЭТ) хүлээн зөвшөөрөгдсөн Уугуул иргэдийн тусгайлсан эрх юм.

Австралийн Оксфам байгууллагаас төслийн нөлөөлөлд нэрвэгдсэн оршин суугчид өөрсдийнх нь эрх ашиг хөндөгдсөн нөхцөлд шийдвэр гаргахад нөлөөлөх, зөвлөлдөх эрхтэй гэж үзэж байна. Уугуул бус иргэд, төслийн нөлөөлөлд нэрвэгдсэн оршин суугчдын хувьд Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийн гол зарчмыг баримтлан шийдвэр гаргахад оролцох, зөвшилцөх, зөвлөлдөх эрхтэй.

Энэхүү гарын авлагын зорилго нь уугуул болоод уугуул бус аль ч ангилалд багтах, төслийн үр дагаварт нэрвэгдсэн оршин суугчдыг хамруулан авч үзэж байгаа юм. Зөвшөөрөл олгох тухай эрхийн хувьд уугуул иргэдийн эрхийг бусад иргэдтэй яг адилхан гэж үзэхгүй гэдэг байр суурьтай байна. Гэхдээ төслийн үр дагаварт нэрвэгдсэн бүх иргэд шийдвэр гаргахад үр дүнтэйгээр оролцон, зөвшилцөх, уугуул бус иргэд “Үгүй” гэсэн бол түүнийг нь төсөл хэрэгжүүлэгчид хүлээн зөвшөөрөх ёстой.

Шат 1



Төслийг хэн боловсруулж,
санаачилж буйг олж мэдэх

Шат 2



Төслийг боловсруулж буй
газраас мэдээлэл хүсэх

Шат 3



Олон нийтийн дунд
хэлэлцүүлэг өрнүүлэх

Шат 4



Олон нийт, төсөл
боловсруулагчидтай зөвшилцөх

Шат 5



Бие даасан зөвлөгөө авах

Шат 6



Хамтаараа хэлэлцэн шийдвэр
гаргах

Шат 7



Төсөл хэрэгжүүлэгчидтэй
байнгын холбоотой ажиллах

Агуулга

Өмнөх үг	1
Хэрэгтэй үгс	6
Эхлэлийг тавих: Яагаад энэхүү гарын авлага хэрэгтэй вэ?, Яагаад заавал одоо хэрэгтэй вэ?	8
Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийн тухай ойлголт,	9
Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрх хаанаас үүдэлтэй вэ? Хэнд хэрэгтэй вэ?	10
Практик алхмууд: Эрхээ хамгаалахын тулд Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийг ашиглах нь	11
Бид хаанаас тусламж, нэмэлт мэдээлэл авах вэ? Байгалийн баялгийн асуудлаар ажилладаг өөр бусад ямар хүмүүс байдаг вэ?	28
Хавсралт 1: НҮБ-ийн Уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглалыг (НҮБУИЭТ) дэмжсэн орнууд	30
Хавсралт 2: Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийн дотоодын хуульд тусгасан тухай судалгаа хийх аргачлал	30
Хавсралт 3: Төсөл хэрэгжих үе шат	32

Үр шим: Танай оршин суугаа хүн амд хүрч буй төслийн үр өгөөжтэй сайн зүйлс юм. Энэ тухай төсөл хэрэгжүүлэгч, засгийн газрын зүгээс оршин суугчидтай хоорондоо зөвшилцөх ёстой.

Үр шимийг хуваалцах: Төслийн нөлөөлөлд нэрвэгдсэн бүх хүмүүст үр шимийг жигд түгээх арга

Зөвшөөрөл: Төслийг хэрэгжүүлэх эсэх дээр зөвшөөрөл олгох шийдвэр гарган төсөл боловсруулагчдад хандах

Зөвлөлдөх: Төсөл боловсруулагчид ба нутгийн ард иргэд хоорондоо шинээр төлөвлөж буй төслийнхөө талаар харилцан санал солилцох үйл явц. Зөвлөлдөх нь зөвшөөрөл өгөхөөс өөр зүйл юм.

Хамтын эрх: Оршин суугчид зэрэг бүлэг хүмүүсийн хамтын эрх юм. Энэ бол зөвхөн нэг хувь хүний эрх биш ээ.

Тунхаглал: НҮБ-ийн системийн хүрээнд дэлхийн улс орнуудаас гаргасан дүгнэлт. Гэхдээ хуульчлагдаагүй. Засгийн газрууд хүлээн зөвшөөрч хамтран ажиллахаар тохиролцсон зүйл юм. Үндэсний хууль тогтоомжид тусгагдсанаар хуульчлагддаг.

Шийдвэр гаргалт: Төслийн үе шат бүрийн хэрэгжилт дээр зөвшөөрөл өгөх эсэхээ шийдэх хамтын шийдвэр гаргах үйл явц

Нүүлгэн шилжүүлэх: Хүмүүс амьдарч байсан газар, гэр орноо алдах

Хэрэгтэй үгс

Эдийн засгийн үр дагавар: Газраа алдсанаас болоод олдог ашгаа алдах

Элит завших: Төсөл хэрэгжүүлэгчидтэй хийх зөвшилцлийг цөөн тооны хүчирхэг хувь хүмүүс ба элитүүд гартаа авч, тэдний хувийн эрх ашиг болон хувирч иргэд оршин суугчид хоосон хоцрох

Байгаль ба нийгмийн орчны үнэлгээ: Төслийн үр дүнгийн нөлөөллийг тодорхойлдог төсөл хэрэгжүүлэхийн өмнө хийгддэг судалгаа. Үүгээр хүмүүс ба байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилготой.

Нөлөөлөл: Томоохон төслийн үр дүнд олон нийтэд үзүүлэх сөрөг нөлөөлөл. Жишээ нь: голын бохирдол, ойг устгах, тосгоныг нүүлгэх. Энэ нь төсөл хэрэгжүүлэгчдэд бус иргэдэд үзүүлж буй үр дагавар юм.

Нөлөөллийн ашгийн гэрээ: Төсөл хэрэгжүүлэгчдийн дагах ёстой оршин суугчидтай харилцан тохиролцсон гэрээ

Олон улсын хууль: Улс орнуудын хоорондын харилцааг зохицуулах хууль. Хүний эрхийн тухайд засгийн газрууд, иргэд олон нийттэйгээ хэрхэн харилцахыг зохицуулна.

Байгалийн баялаг: Төсөл хэрэгжүүлэгчийн хувьд энэ нь эдийн засгийн ашиг болгож болохуйц байгалийн баялаг буюу ой мод, ус гэх мэт. Оршин суугч олон нийтийн хувьд амьдрал ахуйнх нь эх үүсвэр, жишээ нь ундны ус, тариалангийн газар, малын бэлчээр гэх мэт.

Зөвшилцөл: Төсөл хэрэгжүүлэгч ба оршин суугаа иргэдийн хооронд хийгддэг шударгаар явагдах гэрээний нөхцөлүүдийн тухай хэлэлцээр. Эрх мэдлийг зөв хуваарилах ёстой. Зөвшилцөл дуусахаас нааш төсөл хэрэгжиж эхлэх ёсгүй.

Төрийн бус байгууллага (ТББ): Засгийн газраас хараат бус, бие даасан байгууллага. Компани биш ээ. Үүнд сүсэг бишрэлийн байгууллагууд (сүм), иргэний нийгмийн байгууллагууд, олон нийтэд түшиглэсэн байгууллагууд багтана.

Төсөл санаачлагч: Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй банк, компани, ба засгийн газар.

Нүүлгэн шилжүүлэх: Томоохон төсөлд зай тавьж өгөхийн тулд шинэ газар нүүж амьдрах. Заримдаа төсөл хэрэгжүүлэгчийн өмнөөс засгийн газар үүнийг гүйцэтгэдэг.

Эрсдэл: Гэмтэл, алдагдал, аюулд орох. Хувь хүн төдийгүй олон нийт эрсдэлд нэрвэгдэж болзошгүй. Төсөл хэрэгжүүлэгчид мөн эрсдэлд ордог. Жишээ нь, хэрвээ төслийн үр дагаварт нэрвэгдсэн хүмүүстэй зөрчил, маргаан үүсгэвэл нэр хүндээ алдах.

Эхлэлийг тавих: Яагаад энэхүү гарын авлага хэрэгтэй вэ?, Яагаад заавал одоо хэрэгтэй вэ?

Дэлхий даяар томоохон хэмжээний дэд бүтэц ба уул уурхайн үйлдвэрлэл хурдацтайгаар хөгжиж эхэллээ. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхэд байгалийн баялгийг их хэмжээгээр ашиглах шаардлага тавигдаж байна. Үүнд ой мод хийх бэлтгэх, байгалийн тос, эрдэс баялгийг ухах, усан цахилгаан станц барихаар голыг боох зэрэг орж байна. Эдгээр нь хүмүүсийн амьдралд асар ихээр нөлөөлж, тэдний оршин суугаа газар байгаль бас өртдөг.

Хэрвээ тогтвортой хөгжлийг хангах үүднээс хэрэгжүүлвэл төслийн үр дүн хүмүүст сайнаар нөлөөлж болно. Иймээс байгаль, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс ангид байх ёстой.

Харин ихэнх тохиолдолд ийм төслүүд нь хүний эрх зэрэгт удаан хугацааны сөрөг нөлөөг үзүүлдэг. Үүний нэг шалгаан нь төслийг эхлэхийн өмнө байгальд үзүүлэх нөлөөлөл ба оршин суугаа иргэдийн сонирхол, эрхийг хайхрахгүйгээр эхэлсэнд оршдог.

Томоохон хэмжээний хөгжлийн төсөл оршин суугчид олон нийтэд олон янзаар нөлөөлдөг: Доорх хүснэгтээс заримыг нь харуулж байна.

Эерэг үр дүн ба ашиг	Сөрөг үр дагавар ба нөлөөлөл
› Оршин суугчдад ажлын байр нэмэгдэх	› Газраа орхин нүүх
› Чадварын сургалт	› Хүнсний үйлдвэрлэл ба соёлын зориулалттай газрыг ашиглах боломжоо алдах
› Усан хангамж, ариун цэвэр сайжрах	› Ус, агаар бохирдох
› Хүнсний үйлдвэрлэл нэмэгдэх	› Загас, амьтан, ургамал алга болох
› Санхүүгийн ашиг	› Хүчирхийлэл, нийгмийн стресс ихсэх
› Шинэ сургууль, эмнэлэг барилга	› Ажлын байр голдуу түр зуурынх
	› Төсөлд ажиллахаар ирж буй хүмүүс нутгийн хүн амын эрүүл мэндэд хортойгоор нөлөөлдөг

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох гэдэг нь онцгой ач холбогдолтой хамтын эрх бөгөөд төслийг тогтвортой болгоход тустай. Төсөл хэрэгжсэнээс болоод уугуул иргэдийн амьдрал, ахуй нөхцөл, газар нутгийн асуудлыг нь хөндсөн тохиолдолд тэд энэхүү эрхээ хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй. Төслийн үр дагаварт нэрвэгдсэн бусад хүмүүсийн хувьд ч төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх шатанд шийдвэр гаргахад оролцуулан зөвшилцөх ёстой.

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийн асуудал ба шийдвэр гаргахад төсөлд нэрвэгдсэн хүмүүсийг оролцуулан зөвшилцөх асуудал үндэсний хууль тогтоомжинд тусгагдаагүй улс орнуудын хувьд төсөл хэрэгжүүлэгчид энэхүү эрхийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Энэхүү гарын авлага нь төслийн үр дагаварт нэрвэгдсэн олон нийтийн зүгээс НХМЗ-г ойлгож, хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдүүлэх зорилготой юм. Тэдний амьдарч буй газарт төсөл хэрэгжсэн нөхцөлд тэд эрхээ хэрхэн хамгаалах, ямар мэдээллийн эх сурвалжийг ашиглах вэ гэдэг талаар зөвлөмж өгөх юм. Энэ нь төсөл хэрэгжүүлэгчид ба засгийн газрыг хариуцлагатай байлгахын тулд олон нийтийн зүгээс ашиглах хэрэглүүр мөн.

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийн тухай ойлголт

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрх гэдэг нь тухайн орон нутгийн уугуул оршин суугчдын эдлэх ёстой эрх бөгөөд бусад хүмүүсийн зүгээс хүндэтгэн үзэх ёстой зүйл юм. Өөрөөр хэлбэл, тухайн орон нутгийн оршин суугчид энэхүү эрхийнхээ дагуу тэдэнд төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгох, эсвэл олгохгүй байж чадах эрхтэй гэсэн үг.

Дээр дурдсан үг болгон онцгой ач холбогдолтой утгыг илэрхийлдэг бөгөөд үүнийг доор нэг бүрчлэн тайлбарлавал:

- › **Нээлттэй байдлаар** гэдэг нь аливаа засгийн газар ба компанийн зүгээс үзүүлж болзошгүй хүч хэрэглэх, сүрдүүлэх, ов мэх хэрэглэх, хавчих, дарамт шахалт үзүүлэх зэрэг үйлдлээс ангид чөлөөтэй байх.
- › **Хэрэгжүүлэхээс өмнө** гэдэг нь засгийн газраас газрыг тодорхой зорилгоор хуваарилах, аливаа төсөл хэрэгжүүлэхийг батлахын өмнө оршин суугчдаас зөвшөөрөл авах, Танд шийдвэр гаргах боломжийн хугацаа олгох.
- › **Мэдээлэлжсэн** гэдэг нь тухайн төслийг хэрэгжүүлэхийг Таны зүгээс зөвшөөрөх, эс зөвшөөрөх шийдвэрээ гаргахын өмнө төслийн талаар тодорхой мэдээллээр хангагдсан байх (төслийг боловсруулсан байгууллагад тавих ёстой асуултыг 16 ба 17 дугаар хуудаснаас харна уу). Мөн:
 - Энэхүү мэдээлэл нь таны мэддэг хэл дээр ойлгомжтой байдлаар тайлбарласан байх ёстой.
 - Төслийн талаар төсөл хэрэгжүүлэгч байгууллага ба засгийн газраас өгсөн мэдээллээр хязгаарлагдахгүй өөр бусад хэлбэрээр бие даасан байдлаар мэдээллээ олж авах боломжтой байх.
 - Хууль болоод бусад техникийн холбоотой асуудлаар туслалцаа авах шинжээч шаардлагатай бол шинжээчээр ханган, танд туслах ёстой.
- › **Зөвшөөрөл өгөх** гэдэг нь таны зүгээс өөрийн сонголтоор шийдвэр гаргах боломж олгохын тулд төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төслийн үе шат бүрт оршин суугчдын саналыг харгалзан, “Тийм”, “Үгүй” гэсэн шийдвэрийг заавал сонсож байх ёстой.

Уугуул бус оршин суугчдын хувьд танд хамаатай асуудлаар шийдвэр гаргах явцад зөвшилцөх, зөвлөмж өгөх эрхээ эдлэхэд энэхүү НХМЗ-ийн зарчмуудыг баримтлах ёстой. Зөвшилцөх ба зөвлөмж өгөх үйл ажиллагааг шийдвэр гарахаас нь өмнө, таныг албадахгүйгээр оролцуулах ёстой бөгөөд зөвшилцөх эсдвийн талаар Та урьдчилж мэдээлэлжсэн байх ёстой.

НХМЗ нь оршин суугчдын эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахдаа тэдэнтэй заавал зөвшилцөх ёстой гэсэн эрхийг нь хамгаалж байгаа хэрэг юм. Энэ нь шийдвэр гаргах уламжлалт үйл явц байж болно. Зарим тохиолдолд оршин суугчдын зүгээс өөрсдийн төлөөллийг сонгон, төсөл хэрэгжүүлэгч талтай зөвшилцөх замаар оршин суугчдын өмнөөс шийдвэр гаргахад оролцдог.

Санамж: НҮБ-ийн Уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглалын зүйл нэг бүрийг цаг заваа гарган уншиж ойлговол НХМЗ-ийг ойлгоход танд тустай билээ.


Уламжлалт байдлаар шийдвэр гаргадаг бодит байдалд төсөл санаачлагчдын зүгээс өөрсдийн шийдвэрийг хүчээр тулган хүлээлгэх оролдлого гаргахын эсрэг оршин суугчид анхааралдаа авч хамгаалах ёстой.

НХМЗ хаанаас эх үндэстэй вэ? Хэнд хэрэгтэй зүйл вэ?

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох тухай эрх нь олон улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн эрх юм. Үүнийг Филиппин, Австрали (гэхдээ муж, аймгуудын хууль нь харилцан адилгүй) зэрэг зарим орны хууль тогтоомжиндоо тусгасан байгаа.

НХМЗ нь хөгжлийн төслийн сайн туршлагад тооцогддог. Томоохон хэмжээтэй хөгжлийн төслийн хувьд энэ нь хөрөнгө оруулж буй компанид ач тустай зүйл юм. Жишээ нь, үйл ажиллагааны эхнээс нь оршин суугчид шийдвэр гаргахад хамтран оролцоод явбал компани ба оршин суугчдын хооронд үүсч болзошгүй зөрчлийн багасгаж өгдөг. Мөн засгийн газрын зүгээс иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахад тусална.

Доорх бүдүүвчээс НХМЗ анх хаанаас үүсэлтэй болох, хэнд хамаатай болохыг харуулж байна.



Жич: Олон улсын хүний эрхийн тунхаг-Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын үндсэн пактууд зэрэг бүгдээрээ төслийн үр дагаварт нэрвэгдсэн оршин суугчдын НХМЗ-ийн зарчмуудыг хэрэгжүүлэхтэй нягт холбоотой юм.

Практик алхмууд

Эрхээ хамгаалахын тулд НХМЗ-г ашиглах нь



Үе шат 1:

Төлөвлөж буй төслийг хэн боловсруулж буйг олж мэдэх

Юуны өмнө, танай оршин суугаа газарт чинь хамааралтай хэрэгжихээр төлөвлөж буй төслийг хэн боловсруулж буйг олж мэдэх хэрэгтэй. Ингэснээр танаас зөвшөөрөл авах ёстой хүн нь хэн бэ гэдгийг олж тогтооно.


Төслийг санаачлагч нь дараах хүмүүс байж мэднэ:

- › Танай засгийн газар
- › Хувийн компани (уул уурхай ба барилгын компаниуд)
- › Өөр бусад орны засгийн газар
- › Орон нутгийн байгууллага (байгаль орчныг хамгаалах газар, байгаль орчин, эрдэс баялгийн яам гэх мэт)
- › Банк юм уу олон улсын санхүүгийн байгууллага (Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Африкийн хөгжлийн банк)

Заримдаа төсөл боловсруулагчдын талаар мэдээлэл олж авахад хүндрэлтэй байдаг. Томоохон төслүүд нь засгийн газар ба хувийн салбарын аль алиных нь сонирхлыг нэгтгэсэн байдаг. Төслийн талаар мэдээлэл олдохгүй бэрхшээл учирвал ТА олон улсын төрийн бус байгууллага юм уу, дотоодын төрийн бус байгууллагад хандах хэрэгтэй. Олон улсын мэдээллийн хэрэгсэл, сонин сэтгүүл зэрэг нь (жишээ нь уул уурхайн мэдээллийн сэтгүүл) төлөвлөж буй төслийн тухай мэдээлдэг.

Зарим тохиолдолд төсөл санаачлагч нь гадаадын тал байж болно. Ийм тохиолдолд танд мэдээлэл авахад туйлын хүндрэлтэй учраас та өөр бусдын тусламж дэмжлэг авах хэрэгтэй.

ХЭН ХАРИУЦДАГ ВЭ?



Таны зөвшөөрлийг хүсэх ёстой төслийг боловсруулж буй хүмүүс нь зарим тохиолдолд дээрх олон газруудын нэгдэл байдаг.

ЗӨВЛӨМЖ 1:

Хөрш орнуудад байгалийн нөөц баялаг ба газрыг ашиглахад тусалдаг ямар нэг байгууллага ажилладаг эсэхийг судалж мэдэх. Жишээ нь, тухайн орны гол, усны менежмент хийхэд тусалдаг байгууллага байгаа эсэхийг судлан, хэрвээ байдаг бол танай засгийн газар хамтардаг эсэхийг тогтоох. Далан барих төслийн талаар Та санаа тавьж байгаа бол тэднээс хэрэгтэй мэдээлэл олж авч мэднэ.



Үе шат 2:

Төсөл боловсруулагчдаас мэдээлэл хүсэх

Хэлэлцэгдэж байгаа төсөл нь танай оршин суугчид олон нийтэд хэрхэн нөлөөлөх талаар эхлээд олж мэдэх ёстой. Ингэснээр Та мэдээлэлжсэн байдлаар шийдвэр гаргана:

- › Зөвшөөрөх эсэхээ шийднэ
- › Төслийн аргачлалд өөрчлөлт оруулах эсэхээ шийднэ
- › Төсөл эхлэхийн өмнө хэрэгжүүлэх ёстой шаардлагуудыг тогтоож авна

Төслийн зүгээс олон нийтэд үзүүлэх нөлөөллийн талаар “Эхлэлийг тавих: Яагаад энэхүү гарын авлага хэрэгтэй вэ?, Яагаад заавал одоо хэрэгтэй вэ?” хэмээх бүлэгт өгүүлсэн байгаа.

Танай оршин суугаа газрын иргэд төслийн сөрөг нөлөөлөлд өртлөө гэж үзвэл, таны ярьдаг хэл дээр төсөл хэрэгжүүлэгчид мэдээллээр хангах ёстой. Хүмүүс төслийн талаар бүрэн дүүрэн мэдээлэлтэй байж, төслийн үр дагавар юу болох, түүнийг багасгах талаар төсөл хэрэгжүүлэгчид юу хийж буйг мэдэж байвал зохино.

Өөрийн ярьдаг хэл дээр чинь бичигдсэн Байгаль ба нийгмийн орчны үнэлгээний хувийг шаардаж авах хэрэгтэй. Энэ нь бүх иргэд гарах үр дагаврын талаар мэдэж авахад тустай. Зөвшилцөх үйл явцад бүх хүмүүсийн эрх ашгийн үүднээс бус харин олон нийтийн төлөөлөл хэмээн нэрийдэж хувийн ашиг хонжоо хайсан цөөхөн хэдхэн хүнийг оролцуулдаг аюулыг багасгахад энэ тусална.

Төслийн газар зүйн байршил, хамрах хүрээ, төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс төслийн нөлөөлөлд өртөгсдийг зөв тодорхойлсон эсэх зэргийн талаар Та мэдэх ёстой. Танай оршин суугаа нутаг дэвсгэрийн иргэдийг “нөлөөлөлд хүчтэй өртөгсдийн” тоонд багтаагаагүй гэдэг үндэслэлээр төсөл хэрэгжүүлэгчид та нартай зөвшилцөл хийхээс зайлсхийх талтай.

Эдгээр мэдээллийг олж мэдэх нэгэн арга нь төсөл хэрэгжүүлэгчдэд тавих асуултууд бөгөөд дараачийн хуудсанд асуух асуултын жагсаалтыг өгсөн байгаа. Асуултуудыг сайтар мэдэж аваад иргэдтэй уулзахдаа хэлэлцвэл зохино.

Өөрийн орны засгийн газрын харьяа байгууллагууд болох Байгаль орчны яам, Ойн газар, Уул уурхайн яам, Хөдөө аж ахуй ба Сангийн гээд олон газраас мөн эдгээр асуултыг асууж болно. Орон оронд энэ байгууллагуудын үүрэг янз бүр байгаа.

Төсөл танай оршин суугаа нутаг дэвсгэрт хэрэгжээгүй ч гэсэн та нар түүнд өртөгсөд байж болдог. Жишээ нь, усны бохирдол нь төсөл хэрэгжих газраас хальж хөрш хүмүүс, газар нутагт нөлөөлж болно. Далан барьснаар загасны урсгалыг боогдуулан, хүмүүсийн идэх хоол хүнсний хангамж, ахуйд шууд нөлөөлдөг.

Санамж: Төсөл өөр улс орны нутаг дэвсгэр дээр хэрэгжиж байлаа ч та нарын оршин суугаа газарт нөлөөлж болдог. Жишээ нь, өөр оронд ажиллаж буй уурхайгаас танай нутаг руу нөлөөлж, уурхайн хаягдлаас болоод голын урсгал боогдох, хүмүүсийн усны хангамжийг дутаглалд оруулж болдог.

ЗӨВЛӨМЖ 2:

Танай оршин суугаа иргэдэд ойлгомжтой байдлаар бичигдсэн, эх хэл дээрээ мэдээлэл авахыг шаардах ёстой.

Төслийн талаар ойлгож мэдэх тухай

- › Ямар зорилготой төсөл вэ? Ямар үйл ажиллагаа явуулах вэ?
- › Хэр зэрэг том хэмжээний төсөл вэ? Хэрхэн баригдах вэ? Хэр удаан хугацаанд үргэлжлэх вэ?
- › Төсөл боловсруулагчид нь хэн бэ? (Жишээ нь, засгийн газар уу компани уу?)
- › Компаний урьд нь хийж гүйцэтгэсэн ажлууд юу вэ? Тэдний нэр хүнд ямар түвшинд байна?
- › Хөрөнгө оруулалтын зээлийг олгогч нь хэн бэ? (жишээ нь, арилжааны банк уу, Дэлхийн банк уу, хөрөнгө оруулалтын сан уу?)
- › Төсөл хэрэгжүүлэгчийн гол эрхэлдэг бизнес юувэ?
- › Төсөл хэрэгжүүлэгчид аль улсынх вэ?
- › Төслийн дүнд юу хийгдэх, баригдах вэ? (жишээ нь зам тавих уу, далан босгох уу, томоохон цахилгааны шугам тавих уу?)
- › Засгийн газар ба компаниас гадна төсөлд хэн оролцох вэ? (нийлүүлэгчид, барилгын компани гэх мэт)
- › Засгийн газраас ямар дэмжлэг үзүүлдэг вэ? (жишээ нь татварын хөнгөлөлт үзүүлдэг үзүүлдэггүй эсэх, газар ашиглалтын төлбөр татвар гэх мэт)
- › Төслийн талаарх танай орон нутгийн удирдлагын санаа бодол?

Жич: Эдгээр нь зөвхөн санаа өгөх асуултууд юм. Төслийн холбоотой нарийн ширийн олон зүйлсийг нэмж асууж болно. Өөрийн нутаг оронтой холбоотой, соёл уламжлалтай холбоотой зэрэг олон асуултууд байж болно.

Төсөл
боловсруулагчдаас
асуух зарим
үлгэрчилсэн асуултууд

Төслийн нөлөөллийг тодорхойлох асуултууд

- › Ямар газар нутагт нөлөөлөл үзүүлэх вэ?
- › Нөлөөлөх газар нутгийн байршлын зургийг гаргасан уу? Газар ба байгалийн бусад нөөцөд үзүүлэх нөлөөлөл нь тогтмол явагдах уу?
- › Төсөл боловсруулагчдын зүгээс төслийн хүний эрх, байгаль орчин, жендер, ба нийгмийн нөлөөлөх байдлын судалгааг гаргасан уу?
- › Төслийн эрсдлүүд юу вэ? (Жишээ нь, агаарын бохирдол ба тахилгат газрыг хамрах)
- › Эдгээр эрсдлийг тооцож гаргасан тайлан байна уу, тайланг хүмүүс олж үзэх боломжтой юу?
- › Орон нутгийн иргэдэд үзүүлэх үр ашиг нь юу вэ? Энэхүү үр ашиг нь байнгынх уу түр зуурынх уу?
- › Компаний зүгээс ард иргэдэд ямар тусламж үзүүлэх вэ? (жишээ нь сургууль барих, зам тавих, эмнэлэгийн үйлчилгээ болоод нийгмийн хөгжлийн бусад хөтөлбөрүүд)
- › Нутгийн ард иргэдийн аюулгүй байдлыг хангах, газрыг хадгалах зэрэгт компани яаж нөлөөлөх вэ? Хэрвээ мөсөл боловсруулагчид газрыг нь авах бол газрын оронд нөхөн шинэ газар олгож өгөх үү?

Олон нийттэй зөвлөлдөх ба зөвшилцөх

- › Төслийн төлөвлөгөөг зураглан гаргахад олон нийтийг хэрхэн оролцуулж байгаа вэ? Үүнийг хэрхэн зохицуулах вэ?
- › Байгаль ба нийгмийн нөлөөллийн үнэлгээг гаргахад олон нийтийн зүгээс хэрхэн оролцох вэ?
- › Байгаль ба нийгмийн нөлөөлөх байдлын үнэлгээг ямар байгууллагаас боловсруулсан, илтгэлийг эх хэл дээрээ үзэх боломжтой юу?
- › Компани ямар хүмүүстэй зөвлөлддөг вэ? Олон нийтийн зүгээс зөвшөөрөл авах ёстой гэдгээ компани мэдэж байгаа юу?
- › Төслийн төлөвлөгөөнд аливаа өөрчлөлт орвол үүнийг дагаад ямар зүйлс хийгдэх вэ?
- › Төслийн хэрэгжилтийн үе шат бүрт компани олон нийтийг хэрхэн оролцуулахаар төлөвлөсөн бэ?
- › Төслийн зүгээс олон нийтийн хүсэл, сонирхлыг хэрхэн хүлээн авч харгалзах вэ?
- › Төслөөс олох бүх ашиг болоод төлбөрийн тухай мэдээллээ нээлттэй байлгах уу?
- › Төслөөс олох ашгийг юунд зарцуулах вэ?



Үе шат 3:

Олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх нь

Төсөл хэрэгжүүлэгчидтэй холбоо тогтоож эхэлмэгц өөрийн нутгийнхантайгаа төслийн талаар дэлгэрэнгүй хэлэлцэж эхлэх нь зүйтэй. Хэрэгжүүлэхээр зэхэж буй төслийн талаар бүх хүмүүс мэдэж авах ёстой. Хүмүүст мэдээлэл хүргэхдээ газрын зураг, брошюр, зурагт хуудас, видео зэргийг ашиглана. Төслийн үр ашиг болоод сөрөг нөлөөллийн талаар хүн бүр ойлгоход тустай. Хамгийн чухал асуудал юу вэ гэдгийг нутгийн иргэд л шийднэ. Түүний дараа олон нийтээс төлөөлөл гарч төсөл боловсруулагчидтай уулзаж олон нийтийн шийдвэрийн дагуу цаашдын алхмаа тохирно.

Тохиролцоонд хүрэхийн тулд олон нийтийн санаа бодолд нийцтэй аргыг ашиглан өөрсдийн асуудлыг хэлэлцэнэ. Төслийн нөлөөлөлд өртөж буй хүн бүрийн санаа бодлыг авах ёстой. Ялангуяа эмэгтэйчүүд, залуучууд шийдвэр гаргахад оролцох хэрэгтэй. Учир нь томоохон хэмжээний төсөл хүн бүрт харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг.


Төслийн нөлөөлөлд өртсөн хэд хэдэн бүлэг голдуу байдаг. Төсөл боловсруулагчид бусад газрын иргэдтэй хэрхэн ажилладаг тухайгаа та нартай хуваалцах ёстой. Ижил төстэй төслийн нөлөөлөлд өртсөн бусад хүмүүсийн тухай мэдэж авах нь чухал юм. Засгийн газар юм уу төсөл боловсруулагчидтай тохиролцоонд хүрэхэд тэдэнтэй та бүхэн хамтарч ажиллах боломжтой.

ЗӨВЛӨМЖ 3:

Энэ үе шатанд та ямар ч шийдвэр гаргах ёсгүй.
Хамгийн эхний шийдвэр нь эхлээд төсөл боловсруулагчдаас мэдээлэл олж авах явдал юм.

Нутгийн иргэдийн зарим хэсэг нь төслийг дэмжиж байхад бас эсэргүүцсэн хэсэг байдаг. Зарим тохиолдолд төсөл боловсруулагчдын зүгээс иргэдийг хооронд нь “эсрэг” багууд болгон талцуулахыг оролддог. Ийм тохиолдолд нутгийн иргэд хамтарч шийдвэр гаргахад бэрхшээл учирч, цаашдаа олон нийтийн дунд зөрчил үүсэх магадлалтай.

Төслийн нөлөөлөлд хэд хэдэн бүлгүүд өртөж болох ба түүний дундаас нэг бүлэгт нөлөөлөл илүү хүчтэй тусч байх тохиолдол бий. Ийм тохиолдолд бусад бүх бүлгүүдтэйгээ хамтарч нэгдэн нэгэн дуу хоолойгоор тэмцэх нь чухал.



Үе шат 4:

Төсөл боловсруулагчидтай хийх олон нийтийн зөвшилцөл

Нутгийн олон нийтийн хувьд та бүгд хамтарч зөвлөлдөн, төсөл боловсруулагчидтай зөвшилцөл хийх эрхтэй хүмүүс. Төслийнхэнтэй ярилцлага өрнүүлж байна гэдэг нь төслийг шууд хүлээн зөвшөөрлөө гэсэн үг биш ээ. Энэ удаад та зөвхөн төслийн тухай мэдээлэл хүсч авах гэсэн эрхээ л эдэлж байгаа хэрэг.

Төсөл боловсруулагчид та нартай зөвлөлдөж, төслийг төлөвлөх эхний шат төдийгүй төслийн дараачийн шат бүрт шилжих мөчид та нар нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхтэй. Үүний дагуу төслийн эхний шатанд таниас НХМЗ авч, мөн дараачийн шат эхлэхдээ дахин тантай уулзана гэсэн үг. Хэрвээ хүмүүсийг нүүлгэн шилжүүлж болзошгүй тохиолдолд эцсийн шийдвэр гарахаас нь өмнө зөвшөөрөл авах ёстой.

Томоохон хэмжээний барилгын төсөл их ашигтай бизнес. Харамсалтай нь орон нутгийн иргэд энэхүү ашгаас хүртэж чаддаггүй. “Ашгаа хуваалцах” хэмээх механизмыг хэрэгжүүлбэл төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүст хувь ирдэг. Жишээ нь, нутгийн иргэд ямар ашиг тус хүртэхээ өөрсдөө сонгож шийдэх болдог. Үүгээр иргэдийн ахуй амьдралыг сайжруулах боломжтой бөгөөд төслөөс хүмүүст хүрэх ашиг үр өгөөжийг харуулж өгнө.

Төслийн үр ашгийг хэрхэн хүртэх талаар зөвшилцөл хийхэд нутгийн ард иргэд бүгдээрээ оролцох нь хамгаас чухал бөгөөд зөвшилцлийг бусдын нэрээр далимдуулан хувийн ашиг хонжоо хайсан цөөхөн хэдхэн удирдагч буюу “элит” удирдаж болохгүй. Иймээс бүх иргэд “элитүүдэд” эрхээ алдахаас болгоомжлон, зөвшөлцөлд идэвхтэй оролцох ёстой.

Өөрсдийн орон нутгийн эрх ашгийн төлөө зөвшилцөл явуулахад хэрэгтэй зарим жишээ:

- › Ажлын байр нэмэгдүүлэх
- › Чадварын сургалт, ажил олж өгөх
- › Шинэ сургууль эмнэлэг барих
- › Төслийн нөлөөлөлд өртөгсөд төслийн газар нутагт орох, баялгийг эзэмших эрхээ эдлэх ёстой.
- › Соёлын өвийн холбоотой газарт хүрэхгүй байх талаар төсөл боловсруулагчидтай тохирох
- › Төслөөс олох ашгаас хуваалцах

ЗӨВЛӨМЖ 4:

Таныг бэлэн биш байхад зөвшилцөл эхлэхийг төсөл боловсруулагчид шаардах ёсгүй. Мэдээллийг аваад танилцах цаг хугацаа танд өгөх Төслийнхэнтэй зөвшилцөл хэрхэн явуулах, эцсийн шийдвэрээ тохирох зэргээ эхлээд та шийдэх эрхтэй.

ЗӨВЛӨМЖ 5:

Нутгийн иргэдийн зөвшөөрөлгүйгээр барилгын ажлыг эхлүүлсэн тохиолдолд төсөл боловсруулагчдад асуудлыг хүргүүлэх ёстой. Танд үг хэлэх эрх нээлттэй байгаа. Барилгын ажлыг зогсоож, иргэдийн зүгээс нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгосны дараагаар төсөл үргэлжлэх ёстой. Үүгээр төслөөс олон нийтэд өгөх үр ашгийг тодорхой болгож, цаашид төсөл хэрхэн явах талаар тохиролцоонд хүрнэ.



Үе шат 5:

Бие даасан зөвлөгөө хүсэх

Төсөл боловсруулагчидтай нүүр тулж, зөвшилцөл явуулах нь амаргүй байх талтай. Учир нь тэд зарим тохиолдолд орон нутгийн иргэдийг оролцуулахгүйг хичээдэг. Хэлэлцэх асуудлууд ч бас нарийн түвэгтэй байдаг. Хэрэгжүүлэхээр зэхэж буй төслийн нөлөөллийн талаар танд дэлгэрэнгүй мэдээлэл зөвлөгөө хэрэгтэй бол та хуулийн болоод техникийн зөвлөгөө авах эрхтэй. Жишээ нь, компани нь үйл ажиллагаандаа мөнгөн усыг ашиглана хэмээн танд хэлэхэд та мөнгөн усны талаар сайтар ойлголтгүй байвал мэргэжлийн шинжлэх ухааны эрдэмтнээс мэдээлэл авах хэрэгтэй болно.

Хамгийн гол нь та шийдвэр гаргахдаа мэдээлэлтэй байж л асуудлыг шийдэх ёстой. НХМЗ-ийн үндсэн нэг зарчим нь нутгийн уугуул иргэд төслийн талаар урьдчилж мэдээлэл авсны үндсэн дээр шийдвэрээ гаргах ёстой гэж үздэг. Төслийн нөлөөлөлд өртөж байгаа бусад нийгмийн бүлгүүдийн хувьд ямар асуудлыг хэлэлцээд зөвшилцөж байгаа талаар мөн мэдээлэл авсны үндсэн дээр хэлэлцээрт оролцох ёстой.

Төсөл боловсруулагчдаас ирүүлсэн мэдээллээс гаднаа бусад сувгаар мэдээллийг авах нь чухал. Нөлөөлөлд өртсөн хүн амын сонирхлыг татаж, тэднээр төслөө зөвшөөрүүлэхийн тулд тэд ташаа мэдээлэл тараах талтай. Тийм учраас бусад эх сурвалжаас мэдээлэл авснаар төслийн үр дагаврыг бүрэн дүүрэн ойлгож мэдэж авахад тусална. Танай хүн ам ямар эрх эдлэхээ мэдэж авна.

Жич: Танай улсын үндэсний хууль тогтоомжид НХМЗ-ийн эрхийн талаар хэрхэн тусгасан, иймэрхүү ижил төстэй үйл явцын талаар байдаг эсэхийн талаар мэдэж авахын тулд бие даасан хуулийн зөвлөгөө танд тусална.

28 дугаар хуудаснаас бие даасан зөвлөгөө хэрхэн авах тухай дэлгэрэнгүй олж үзнэ үү.

Үндэсний хууль тогтоомжид НХМЗ-ийн эрхийг хамгаалах талаар оруулсан хэдий ч заримдаа хэрэг буруу тийшээ эргэдэг тохиолдол бий. Авилга, хууль хэрэгжихгүй байдал, НХМЗ-ийг хэрэгжүүлэхээр оноосон байгууллагууд бие дааж ажиллах чадваргүй байх зэргээс болоод иргэд НХМЗ-ийн эрхээ эдэлж чадахгүй хүндрэл бэрхшээлд хүрч болзошгүй юм.



Үе шат 6:

Олон нийтээрээ хамтарч шийдвэрээ гаргах

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрх нь хамтаараа хэрэгжүүлэх ёстой эрх юм. Иймээс танай нутгийн оршин суугчид хамтарч урьд өмнө нь хэрхэн шийдвэр гаргадаг уламжлалтай байсан түүнийхээ дагуу шийдвэр гаргах ёстой.

Хэрвээ та нар төслийг хэрэгжүүлэхэд “За” хэмээн зөвшөөрч байгаа бол төсөл хэрэгжүүлэгчидтэй бичгээр үүнийгээ баталгаажуулж үлдээх хэрэгтэй. Үүнийгээ өөрсдийн ярьдаг эх хэл дээрээ бичнэ, энэ баримт бичиг хууль зүйн үүднээс хүчин төгөлдөр байх ёстой.

Энэ үйл явц бүхэлдээ нилээд түвэгтэй зүйл юм. Төслийн гэрээг ойлгож мэдэх, засгийн газраас баталсан баримт бичиг, хууль эрхийн актууд нь их хэцүү зүйлс. Гэрээ ба бусад баримт бичгийг ойлгоход түвэг учирвал энэ чиглэлийн туршлага мэдлэгтэй хүмүүс, ТББ-ын туслалцаа авах хэрэгтэй юм.

Төсөл хэрэгжүүлэхийг та нар зөвшөөрсөн тохиолдолд төслийн байгууллагатай төслийн үр ашгийн тухай гэрээг байгуулж болно. Энэ бол төсөл хэрэгжүүлэгчид ба танай оршин суугчдын хооронд хийгдэж буй хуульчилсан баримт бичиг юм. Үүнд төсөл хэрэгжүүлэгчид ямар шаардлагыг биелүүлэх ёстой, эдгээр шаардлагыг хэр биелүүлэх боломжтой зэргийг тодорхойлдог.

Санамж: Хэрвээ танай нутгийн оршин суугчдын хувьд төслийн үр ашиг хангалтгүй гэж үзвэл төслийг хэрэгжүүлэхэд “Үгүй” гэсэн хариу өгч зөвшөөрөхгүй байж болно. Энэ тохиолдолд засгийн газар ба төсөл боловсруулагчдын зүгээс нутгийн уугуул иргэдээс заавал зөвшөөрөл авч байж төсөл цааш үргэлжлэнэ. Уугуул бус, төслийн нөлөөлөлд өртөж байгаа бусад нийгмийн бүлгийн хувьд тэд “Үгүй” гэх юм бол үүнийг бас анхаарах ёстой.

Зарим төсөл боловсруулагчдын зүгээс гаргадаг үйлдэл бол газар эзэмшигч ба тэдний төлөөллийг архинд “согтоох” замаар төслөө хэрэгжүүлэх “зөвшөөрөл”-өө авах, баримт бичиг дээрээ хүчээр гарын үсгийг нь авах оролдлого гаргадаг.

Зарим тохиолдолд төсөл боловсруулагчид өөрсдийн шийдвэр гаргах аргачлалыг боловсруулан иргэдээр “За” гэж хэлүүлэхэд хүргэдэг. Ийм арга нь иргэдийн өөрсдийн уламжлалт шийдвэрээ гаргадаг аргаас өөр, хүмүүсийн албан ёсны төлөөллийг оруулахгүйгээр, хуурмаг аргаар “За” гэж зөвшөөрүүлэхэд чиглэдэг.

Санамж: Төсөл боловсруулагчид нь ямар нэг аргаар та нарыг зөвшөөрүүлэхийн тулд хүч хэрэглэх, сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлэх зэргээр аашлах эрхгүй. Төсөл боловсруулагчдын зүгээс энэхүү шийдвэр гаргах үйл явцыг хүндрүүлдэг зарим жишээг дурдвал:

- › Нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эхний шатанд олон нийтийг оролцуулахгүй байх
- › Төслийн нөлөөллийн талаар хүмүүс ойлгоогүй байхад гарын үсэг зурахыг хүчээр шаардах
- › Олон нийтийн санаа бодлыг төлөөлөх боломжгүй цөөхөн хэдхэн хүнтэй уулзаж тохиролцоо хийх



Үе шат 7:

Төсөл боловсруулагчидтай байнгын харилцаа тогтоох

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох нь байнгын үргэлжилдэг үйл явц юм. Томоохон хэмжээний хөгжлийн төслийг төлөвлөх, дараа нь төслөө эхлүүлэхэд нилээд олон жил зарцуулдаг ба нутгийн иргэд олон жилийн турш нөлөөлөлд өртөж болзошгүй. Төсөл боловсруулагчид нь төслийн үйл явцын талаар олон нийтэд байнга мэдээлж байх ёстойг мэдвэл зохино. Та бүхэн тэднээс асуулт асууж, өөрсдийн санаа бодлоо хүргэж байх ёстой. Танай орон нутгийн иргэдийн нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийг байнга хүндэтгэх ёстой.

Томоохон хэмжээний төслийн үргэлжлэх үе шатны талаар 32 дугаар хуудасны 3 дугаар хавсралтад харуулж байна. Үүгээр төслийн үе шат бүрт хийгдэх гол үйл ажиллагааны талаар, үе шат бүрт олон нийтийг оролцуулахын тулд төсөл боловсруулагчид юу хийх тухай оруулсан байгаа.

Санамж: *Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох гэдэг нь “нэг удаагийн” арга хэмжээ биш ээ, энэ бол байнгын үргэлжлэх процесс. Төсөл боловсруулагчид ба төслийн нөлөөлөлд өртсөн ард иргэдийн хооронд байнгын харилцаа тогтоон, харилцан ойлголцох сайн туршлага юм.*

Та төсөлд “За” эсвэл “үгүй” гэдгээ хэлсэн бол олон нийтийн төлөөлөл болсон хүмүүс таны өмнөөс зөвшилцөл явуулах ажлыг үрөгэлжлүүлнэ. Хамгийн гол нь үйл ажиллагааны тухай бүх хүмүүст мэдээлэл хүрсэн байх ёстой.

Зөвлөмж 6:

Мониторинг хийдэг бие даасан байгууллагын туслалцаатайгаар төслийн нөлөөлөл ба амлалтууд нь хууль ёсных гэдгийг төсөл боловсруулагчдад ойлгуулах

Зөвлөмж 7:

Төсөл дуусахаас өмнө төсөл дуусгавар болсны дараах стратеги гэдгийг төсөл хэрэгжүүлэгчидтэй зөвшилцөн тохирох ёстой. Үүнд цэвэр усны хангамж, засвар үйлчилгээ, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх дахин сургалт зэрэг зорилтуудыг тусгана.

Төсөл хэрэгжиж эхэлмэгц олон нийтийн төлөөллийн зүгээс төслийн үйл ажиллагаанд мониторинг хийх хэрэгтэй. Олон нийтийн зүгээс компани ба засгийн газар нь амлалтаа хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих нь чухал. Үүний нэг хэлбэр нь төслийн онцгойлсон үр дүн ба нөхцөлүүдийг тохирох явдал. Үүнийг бичгээр баталгаажуулан цаг хугацааг нь тохирох ёстой.

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн явцад солигддог. Төслийн өмнөх удирдлагатай хийсэн амлалтуудыг шинэ удирдлага үргэлжлүүлэх ёстой. Шинэ удирдлага нь амлалтуудыг үргэлжлүүлж байгаа эсэхийг ойлгож авахын тулд бие даасан зөвлөгчийн туслалцаа авч болно. Ийм учраас л төслийн нөлөөлөл, иргэдэд өгөх үр ашгийн талаар бичгээр зөвшилцлөө баталгаажуулах нь чухлыг хэлж байна. Шинэ төслийн багт өөр бусад нэмэлт хүсэлт тавьж зөвшилцөх асуудал бол та нарт нээлттэй.

Төслийнхөнтэй байнгын харилцаатай байхын тулд хамтын уулзалт, форум хийдэг уламжлалыг тогтоох хэрэгтэй. Төсөл хэрэгжих явцад танай иргэдийг зүгээс гарч буй шинэ асуудлууд, санал гомдлыг энэ форумоор хэлэлцэх ёстой.

Дээр өгүүлсэн алхмууд нь та бүхнийг нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж, зөвлөлгөө авах, танд холбоотой асуудлаар шийдвэр гаргахад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд туслах зорилготой юм.

Бид хаанаас тусламж, нэмэлт мэдээлэл авах вэ? Байгалийн баялгийн асуудлаар ажилладаг өөр бусад ямар хүмүүс байдаг вэ?

Засгийн газар юм уу, төсөл боловсруулагчийн зүгээс таныг огт сонсохгүй байвал яах ёстой вэ? Дээр заасан аргаар яваад болохгүй, төсөл нь үргэлжлээд байвал юу хийвэл зохих вэ? Ийм нөхцөлд танай орон нутгийн нөхцөл байдал, хүмүүсийн хэрэгцээ онцлогт тохирсон нөлөөллийн ажлын стратегийг боловсруулах хэрэгтэй. Үүнд: олон нийтийн эсэргүүцлийн жагсаал хийх, тайван замаар эсэргүүцэх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг дотоодын ба гадаадын ТББ, олон улсын байгууллагад зориулсан мэдээллийг хэвлэл мэдээллээр тэдний сонорт хүргэх.

Гол хэрэгслүүд

- › *Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ийн тунхаглал (НҮБУИЭТ),*
<http://www.un.org/esa/socdev/unpfii/declaration.html/>
- › *Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох нь: Уул уурхайн компаниудын үүрэг, Оксфам, Австрали, 2007*
http://www.oxfam.org.au/campaigns/mining/docs/FPIC_statement.pdf
- › *Үндсийг тайлах нь: Олон нийтийг уул уурхай ба дэд бүтцийн төсөлд оролцуулах нь, Дэлхийн нөөцийн институт, 2009*
<http://www.wri.org/publication/breakin-ground-engaging-communities>
- › *Австралийн уугуул иргэдийн хүний эрхийг хүндэтгэхэд ЧӨЛӨӨТ ба ТЭГШ байх: Олон нийтийн нөлөөллийн гарын авлага, Оксфам Австрали ба Дипломатын сургалтын хөтөлбөр, 2009*
http://www.dpt.unsw.edu.au/documents/freeand equal_FALR_002.pdf
- › *Далан, гол ба эрх: Далангийн төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийн гарын авлага, Олон улсын гол мөрний сүлжээ байгууллага, 2006*
<http://www.internationalrivers.org/en/node/579/>
- › *Эмнэсти интернационал байгууллагын кампанит ажлын гарын авлага, 1997*
www.amnesty.org.en/library/info/ACT/10/002/1997
- › *Халамжлахын төлөө нөлөөллийн ажиллагаа явуулах хэрэгслүүд ба гарын авлага: Бодлогын өөрчлөлт хийх, 2001*
http://www.care.org.getinvolved/advocacy/tools/english_00.pdf
- › *Нийгмийн шударга ёсны гарын авлага: Глобал түвшний үйл ажиллагаа ба хэрэгжүүлэх гарын авлага. 2001*
www.oxfamamerica.org.publications/advocacy-for-social-justice

Байгууллагууд

Нэгдсэн Үндэстний Байгууллага

- › Уугуул иргэдийн хүний эрх ба суурь эрх чөлөөний байдлын тухай НҮБ-ийн тусгайлсан илтгэгч
<http://www2.ohchr.org/english/issues/indigenous/rapporteur/>
- › Уугуул иргэдийн асуудлаархи НҮБ-ийн байнгын форум
<http://www.un.org/esa/socdev/unpfii/>

Олон улсын төрийн бус байгууллагууд

- › Азийн уугуул иргэдийн пакт: www.aippnet.org
- › Гадаадын хөгжлийн католик байгууллага (ГХКБ): www.cafod.org.uk
- › Ойн иргэдийн хөтөлбөр: www.forestpeoples.org
- › Олон улсын гол мөрөн: www.internationalrivers.org
- › Америкийн нэгдсэн улсын Оксфам байгууллага: www.oxfamamerica.org
- › Австрали улсын Оксфам байгууллага: www.oxfam.org.au

Таны оршин суугаа газарт байрладаг байгууллагууд

- › Олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллагууд ба бусад дотоодын ТББ-ууд
- › ТББ-ын форум буюу танай орны бүх байгууллагыг хариуцдаг толгой байгууллага
- › Танай нутагт байгаа хуулийн зөвлөгөө өгөх газар
- › Танай орон нутгийн удирдлага (байгаль орчныг хамгаалах газар, байгаль орчны яам, эрдэс баялгийн яам гэхчлэн)

Хавсралт 1:

Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ийн тунхаглал (НҮБУИЭТ)-ыг дэмжсэн улс орнууд

НҮБУИЭТ нь тунхаг бичиг юм. Олон улсын хуулийн үүднээс үзвэл энэ бол улс орнуудыг заавал биелүүлэхээр хуульчилсан зүйл биш, гэхдээ л чухал ач холбогдолтой, улс орны засгийн газрууд, олон улсын хамтын нийгэмлэг харилцан ярилцаж тохиролцсон стандарт юм.

Танай засгийн газар энэхүү тунхаглалыг дэмжсэн бол эдгээр эрхийг хамгаалахын төлөө ажиллахыг зорих ёстой.

10 дугаар хуудсанд байгаа загвар зургаар уугуул иргэдийн эрхийг хангахад УИЭНҮБТ-ийн ач холбогдол, тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн талаар харуулав.

УИЭНҮБТ-г 147 орон дэмжсэн

Афганистан, Албани, Алжир, Андорра, Ангол, Антигуа ба Барбуда, Аргентин, Армени, Австрали, Австри, Бахам, Бахрэйн, Барбадос, Беларус, Белги, Бэйз, Бенин, Боливи, Босни Герцеговин, Боствана, Бразил, Бруней Дарусалем, Болгар, Буркина Фасо, Кампуч, Камерун, Кэйп Верде, Төв Африкийн улс, Чили, Хятад, Колумб, Коморос, Конго, Коста Рика, Кроация, Куба, Сайпрус, Чех, Хойт Солонгос, Конго бүгд найрамдах улс, Голланд, Джбуати, Доминик, Доминикан, Эквадор, Египет, Салвадор, Эстони, Финлянд, Франц, Габон, Герман, Гана, Грек, Гватемал, Гвиней, Гуана, Хайти, Гондурас, Унгар, Исланд, Энэтхэг, Индонез, Иран, Ирак, Ирланд, Итали, Ямайка, Япон, Иордан, Казакстан, Кувэйт, Лаос, Латви, Леван, Лесото, Малайз, Малдив, Мали, Малта, Мавритус, Мексик, Макреноса, Молдов, Монако, Монгол, Мозамбик, Мянмар, Намиби, Непал, Нидерланд, Шинэ Зеланд, Никарагуа, Нигер, Норвеги, Оман, Пакистан, панам, Парагвай, Перу, Филиппин, Польш, Португал, Катар, Солонгос, Сайнт Луис, Сайнт Винсент, Гренада, Самоа, Сан Марино, Саудын Араб, Шри ланка, Судан, Сөрнэйм, Свацланд, Швейцарь, Швед, Сирийн араб улс, Танзан, Тайланд, хуучин Югослав, Тимор Лест, Тринидад, Тунис, Турк, Арабын Эмират, Их Британи, Уругвай, Венесуел, Вьетнам, Иемен, Замби, ба Зимбабве.

Эх сурвалж: <http://www.un.org/esa/socdev/unpfii/en/declaration.html>

Хавсралт 2:

НХМЗ-ийн талаар дотоодын хуульд тусгасан тухай судалгаа хийх аргачлал

Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийг дотоодын хууль тогтоомжинд хэрхэн тусгасан тухай ойлгож олж мэдэхэд доорх асуултууд танд тусална.

1. Танай засгийн газраас Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ийн тунхаглал (НҮБУИЭТ)-ийг дэмжихээ илэрхийлсэн болов уу?

30 дугаар хуудасны хүснэгтийг хараад Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ийн тунхаглал (НҮБУИЭТ)-ийг дэмжсэн орнуудын дотор танай орны нэр багйаа эсэхийг шалгана уу. Хэрвээ энэ жагсаалтад ороогүй бол НҮБ-ийн вэбсайтыг шалгаарай.
www.un.org/esa/socdev/unpfii/

2. НХМЗ-ийг дэмжсэн өөр бусад хуульчилсан актууд таниа оронд хэрэгжиж байна уу?

Хэрвээ ТИЙМ бол: Юу гэсэн заалтууд байна вэ?

Хуулиар ямар шаардлага тавьж буйг сайтар шалгана.

Хэнд хамааралтай заалт байна вэ?

Хууль тогтоомж нь төслийн нөлөөлөлд өртсөн бүх хүмүүст хамаатай эсэх, эсвэл зөвхөн уугуул иргэдэд хамааралтай байдлаар хийгдсэн эсэхийг шалгаарай.

Хуулиар ямар арга хэмжээг авахаар заасан бэ?

Өөрийн орны хуулийн заалтуудыг НҮБУИЭТ-ийн заалтуудтай тулган шалга. Яг ямар арга хэмжээ авахаар заасныг сайтар шалгаарай.

Хэрвээ ҮГҮЙ бол: Танай орны дотоодын хууль тогтоомжинд НХМЗ-тай адил төстэй өөр ямар нэг хууль тогтоомж байна уу?

НҮБУИЭТ-тэй ижил төстэй ямар хуулийн заалтууд байгааг шалгах. Энэ талаар төлөвлөлттэй холбоотой хуулиуд зэрэг дэд бүтцийн асуудлаархи хууль тогтоомжид заасан байх талтай.

Хуулиар ямар үйл явцыг шаардаж байна вэ?

Хуульд заасан үйл явцыг судал. НХМЗ-ийн аль чиглэлийг нь хуулинд тусгасан байна вэ? Жишээ нь, олон нийттэй зөвшилцөх аргууд, төлөвлөлт хийхэд тавигдах шаардлага, байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхэд баримтлах зүйлс

3. Нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхийг (НХМЗ) дэмжиж байсантай холбоотой жишиг хэрэг танайд гарч байв уу?

Хэрвээ ТИЙМ бол: Шүүх хэрхэн шийдсэн бэ?

Далан барих, уул уурхай зэрэг томоохон хөгжлийн төслийн нөлөөлөлд өртсөн ард иргэдийн зүгээс нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхээ хэрэгжүүлэхээр шүүхэд хандсан тохиолдлуудаас судалж үз. Шүүхээс иргэдийн асуудалд хэрхэн хандсаныг сайтар судлаарай.

Үүнийг та нарын хувьд авч ашиглаж болох уу? Жишиг гэж үзэж болох уу?

Нөхцөл байдлын хувьд та нарын асуудалтай хэр ойролцоо байгааг судал. Шүүхийн шийдвэрийг анхааралтай авч үз. Та нарын тохиолдолд үүнийг адилхан гэж авч үзэж хэрэглэж болох уу?

Хэрвээ ҮГҮЙ бол үүнтэй адил өөр хэргийн тохиолдол танай оронд гарч байсан уу?

Шүүхээр орсон хэрэг гарч байгаагүй бол томоохон хөгжлийн төслийн нөлөөлөлд өртсөн өөр ямар нэг ард иргэд байгаа эсэхийг судал. Тэд ямар арга хэмжээ авч байгаа вэ? Та нар эрхээ эдлэхэд туслах жишээ байж мэднэ. Танай оронд эхэлсэн төслийг хэрэгжүүлэхийн эсрэг тэмцэж байгаа өөр бусад олон нийтийн бүлгүүд байна уу? Иргэд нээлттэй байдлаар, хэрэгжүүлэхээс өмнө, мэдээлэлжсэн баймааж нь зөвшөөрөл олгох эрхээ эдлэхэд нь туслах зорилготой мэдээлэл түгээх газар байгууллага байна уу?

Хавсралт 3:

Төсөл хэрэгжих үе шат

Төсөл болгон харилцан адилгүй ч бүр төслүүд дараах үе шатыг дамжина. Дараах зургаар төсөлд давтагддаг үе шатуудыг харуулж байна. Төсөл боловсруулагчидтай хэрхэн хамтранх талаар ойлголт өгөхийн тулд дараах мэдээллийг толилуулж байна.

Төслийн үе шат

Төслийн Үзэл Баримтлалыг Тодорхойлох

Үйл ажиллагаа: Томоохон хэмжээний дэд бүтцийн хөгжлийн төслийн үе шат бүрт ямар үйл ажиллагаа явагддаг талаар

Олон нийтийг дайчлах сайн туршлага: төслийн үе шат бүрт олон нийтийг оролцуулахын тулд төсөл хэрэгжүүлэгчдийн зүгээс юу хийх ёстойг харуулж байна

- › Төслийн боломжийг тооцох
- › Орон нутгийн засаг захиргаанаас зөвшөөрөл авах
- › Ашигт малтмалын хайгуул судалгаа хийх

- › Олон нийтийг эхний шатнаас татан оролцуулах
- › Төслийн эрсдлийн судалгааг оролцогч талуудыг хамруулан явуулах
- › Томоохон төслийн хувьд бүх оролцогч талуудын форум хийх

- › Төслийг төлөвлөх
- › Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн судалгаа (БОННС) хийх

- › Хүний эрхийн судалгаа хийх
- › БОННС нь нөхөн сэргээх асуудлыг хамрана
- › Олон нийттэй Ашиг Хүртэх гэрээг байгуулах
- › Олон нийтийн гомдлыг барагдуулах журмыг гаргах

- › Барилгаа эхлүүлэх
- › Газраа худалдаж авах, цэвэрлэх, хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх ажлууд энд багтаж болно

- › Олон нийтэд барилгын ажлын талаар мэдээлнэ, хэлэлцэж өөрчлөлт оруулж болно
- › Гомдол барагдуулах журмыг гаргана
- › Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийг удирдах талаар олон нийтэд мэдээлнэ


- › Барилгын ажлаас гол үйл ажиллагаанд шилжих
- › Үйл ажиллагааны менежмент эхлэх

- › Нөлөөлөлд өртсөн ард иргэдтэй хамтын ажиллагаа үргэлжлэх, хэлэлцээр хийх
- › Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийг удирдах төлөвлөгөөний дагуу осол аваар, агаарын бохирдлоос сэргийлэх
- › Олон нийтийн гомдлыг барагдуулах

- › Төсөл дуусах
- › Үйл ажиллагааг зогсоох

- › Эрх мэдэл шилжүүлэх төлөвлөгөө төслийн удирдлага солигдсон бол өөрчлөх
- › Олон нийттэй зөвшилцөл хийх (судалгааны үе шаттай адилаар)
- › БОННС-ийн нэг хэсэг байх

НХМЗ нь төслийн шийдвэр гаргах гол гол үе шатанд хэрэгжих ёстой



ТББ-д маркаа наах зай

